



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 769

Улаанбаатар хот

### Хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Засгийн газрын 10 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.3, 6.4.3, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн Замын-Үүд дэх Гаалийн газрын дахин төлөвлөлт, шинэчлэлийн ажилтай холбогдуулан ТОГТООХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Замын-Үүд дэх авто тээврийн салбарын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 35,474,248.00 (гучин таван сая дөрвөн зуун далан дөрвөн мянга хоёр зуун дөчин найман) төгрөгийн балансын үнэ, 10,798,294.83 (арван сая долоон зуун ерэн найман мянга хоёр зуун ерэн дөрвөн төгрөг ерэн гурван төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Н.Гүрсоронзон, Замын-үүд салбарын дарга Н.Хатансайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасах, барилгыг буулгаж хоёрдогч түүхий эд болгон ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Боомтын барилга буулгаж, чөлөөлсөн газрыг байгууллагын хилийн боомтын барилга байгууламжийн зориулалтаар нь ашиглах, газрыг нөхөн сэргээх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны  
өдрийн 769 дүгээр тогтоолын хавсралт

**"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Замын Үүд дэх салбарын үндсэн  
хөрөнгөд бүртгэлтэй актлах үндсэн хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиг лалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Хяналтын пост	2019-06-11	35,474,248.00	10,798,294.83	24,675,953.17
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		35,474,248.00 (гучин таван сая дөрвөн зуун далан дөрвөн мянга хоёр зуун дөчин найман)	10,798,294.83 (арван сая долоон зуун ерэн найман мянга хоёр зуун ерэн дөрвөн төгрөг ерэн гурван төгрөг наян гурван мөнгө)	24,675,953.17 (хорин дөрвөн сая зургаан зуун далан таван мянга есөн зуун тавин гурван төгрөг арван долоон мөнгө)